



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн
Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх салбар
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн дарга: - Төрийн нарийн бичгийн дарга,

Гишүүд:


- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,
- Хууль зүйн бодлогын газрын дарга,
- Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,
- Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга,
- Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга,

Салбар зөвлөлийн

нарийн бичгийн дарга: - Төрийн захиргааны удирдлагын газрын
ахлах мэргэжилтэн.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай" Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын "Нэг"-ийн 4 дэх хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг"-ийн 12 дахь хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн Хууль зүйн яамны дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг өөрчлөн томилох тухай" мөн Зөвлөлийн 2015 оны 33 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.ЦОГОО